

## САЛБАР ХУРАЛДААН-2

### НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ

Модератор: Б.Баярболд, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга

Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөний зохион байгуулалтын хүрээнд “НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ” сэдэвт салбар хуралдааныг 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгууллаа.

Салбар хуралдаанд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, аймаг, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Засаг даргын тамгын газар, Дүүргийн Эрүүл мэндийн төв, Нийслэлийн Шүд, эрүү, нүүрний төв, Наркологийн эмнэлэг, Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төв болон Цэргийн төв эмнэлэг, АШУҮИС-ийн Монгол-Японы сургалтын эмнэлэг, Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага болон ДЭМБ, Азийн хөгжлийн банк, Глобал сан зэрэг 50 гаруй байгууллагын удирдах ажилтны төлөөлөл оролцлоо. дирдах ажилтан, дарга, эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн, судлаач 90 гаруй удирдах ажилтан оролцов.

Хэлэлцсэн илтгэл:

1. Нийгмийн эрүүл мэндийн ирээдүйн чиг хандлага, Д.Нарантуяа, НЭМҮТ-н үндэсний төвийн захирал
2. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр 2022 оны хэрэгжүүлэх үйл ажиллагаанд Нийслэлийн эрүүл мэндийн газрын оролцоо, Б.Бямбадорж, Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга

“НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЬЕ” сэдэвт салбар хуралдаанаар хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тулгамдсан асуудал, шийдвэрлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх талаар хэлэлцэн, салбар хуралдаанаас дэвшүүлсэн санал, санаачилгыг сайшаан дэмжиж дараах ЗӨВЛӨМЖИЙГ хүргүүлж байна.

НЭГ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг батлуулах;
2. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах;
3. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;
4. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах;
5. Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах;

## ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээг Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагын чадавх (нөөц, өдөрт хамрагдах хүрээ)-д тулгуурлан ердийн тусламж үйлчилгээний ачаалалд үл нөлөөлөхөөр зохион байгуулах;
2. ЕБС-ийн эрүүл мэндийн боловсрол хичээлийн чанар, хүртээмж, хүний нөөцийн чадавхийг сайжруулах;
3. НЭМ-ийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ, мониторинг хийж хэвшүүлэх;
4. НЭМ-ийн тайван цагийн болон ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний төлөвлөлт;
5. НЭМ-ийн тусламж үйлчилгээг анхан шатны түвшинд нэмэгдүүлэх;

## ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

1. НЭМ-ийн хүний нөөцийн бодлого боловсруулах, сургалтын хэрэгцээг тодорхойлж, чадавхжуулах;
2. Эрүүл мэндийн ажилтны хөрвөх чадварыг сайжруулах, багаар бэлтгэх;
3. НЭМ-ийн мэргэжилтнүүдийн манлайлал, удирдах чадвар, нөлөөллийг нэмэгдүүлэх;

## ДӨРӨВ. ТАНДАЛТ, СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Үндэсний хэмжээнд тодорхой давтамжтай хийдэг судалгаа (Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн судалгаа, Хоол тэжээлийн үндэсний судалгаа...)-ны үр дүн, зөвлөмжийг орон нутгийн онцлогт тохирсон байдлаар гаргах, хэрэгжүүлэх;
2. Орон нутгийн түвшинд НЭМ-ийн судалгаа, мэдээллийн сантай болох;
3. Мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх, боловсон хүчин, лаборатори, техник, тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах;

## ТАВ. САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. НЭМ-ийн тусламж үйлчилгээг нэр, төрлөөр өртөгжүүлэх;
2. НЭМ-ийн эрэлтэд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгох, гүйцэтгэлийн санхүүжилт, зарцуулалт, тайлагналтыг хянах;
3. НЭМ-ийн чиглэлээр ажиллаж байгаа төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээ, хэмжээг тэгшитгэх, нийгмийн баталгааг сайжруулах;
4. Бүх түвшинд хариу арга хэмжээний нөөцийг бүрдүүлэх, шинэчлэх;

## ЗУРГАА: ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Нийгмийн бүх салбарын бодлого, чиглэлд НЭМ-ийн тусламж үйлчилгээний бодлогыг тусгах;
2. Олон улс, донор байгууллагатай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, тайлагналтыг ил тод болгох, үр дүнг бодлогын шийдвэрт ашиглах;

3. НЭМ-ийн бодлого, чиглэлийн талаар Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад чиглэл өгөх, хамтран ажиллах;
  4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хувь хүний хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх;
  5. НЭМ-ийн тусламж үйлчилгээ зорилтот болон өвөрмөц бүлэгт тохирсон байх;
- НЭМ-ийн ноцтой байдлын үед дайчлан ажиллах сайн дурын ажилтан, үе тэнгийнхнийг бэлтгэх, чадавхжуулах